

2023

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

АГУУЛГА

Компанийн түүхэн товчоо.....	1
Эрхэм зорилго, Алсын хараа, Үнэт зүйлс.....	2
Онцлох үйл явдлууд.....	3
Хувьцааны мэдээлэл.....	7
Голлох үзүүлэлтүүд.....	8
Санхүүгийн тайлан мэдээлэл.....	9
Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан.....	12
Шинэ болон шинэчлэгдсэн бүтээгдэхүүн.....	14
MFC 2.0 төслийн үйл явц.....	15



КОМПАНИЙН ТҮҮХЭН ТОВЧОО

Монос Хүнс ХК нь 2012 оноос хүн амын эрүүл мэндийг дэмжих хүнс, хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Бид үндэстний онцлогтой уламжлалт цагаан идээ болон Монгол орны хөрсөнд ургасан анагаах увдистай түүхий эдийг ашиглан тэргүүлэх зэргийн эрдэмтэн судлаачдын олон жилийн судалгаанд үндэслэн бүтээгдэхүүнээ үйлдвэрлэдэг. Нийт 13 брэндийн 71 төрлийн эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж Монгол орны 4 зүг найман зовхист бараа бүтээгдэхүүнээ хүргэх үүднээс нийслэл, 21 аймгийн нийт 6.000 цэгт түгээж байна.



2014

ODOO ERP /Enterprise Resource Planing/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

2012

Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, Монос Хүнс ХХК албан ёсоор үүсгэн байгуулагдав.

Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

2013



2016

Монгол Улсад анх удаа Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.



Монгол Улсад анх удаа Экоc рН8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.

2015



2018

БНХАУ болон Япон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ байршуулснаар албан ёсоор экспортын гараагаа эхлүүлэв.



Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.

2017

2020

Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо ISO22000:2018 болон Хүний нөөцийн менежментийн ISO:30400 стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв. Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.



Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO гаргаж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав

2019



ЭРҮҮЛ МЭНДИЙГ ЦЭНЭГЛЭСЭН 10 ЖИЛ



Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.

2021

"TSC" компанийн OXY дахь салбар "TSC Food Products RU" компанитай хамтран "МИЛИНО" брэндийн ааруултай үрэл бүтээгдэхүүнийг хөгжүүлэн, нийлүүлж эхлэв.

2022



ЭРХЭМ ЗОРИЛГО:

Эрүүл мэндийг дэмжих хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар **ҮЙЛДВЭРЛЭГЧ, ЭКСПОРТЛОГЧ**, дотоодын зах зээлд **ТЭРГҮҮЛЭГЧ** компани байна

АЛСЫН ХАРАА:

ЭРҮҮЛ мэндийг дэмжсэн органик хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд нэвтрүүлэх

ҮНЭТ ЗҮЙЛС:



Шинэ санал,
санаачилга



Мэдлэг, чадвартай
бүтээлч хамт олон



Монгол Оюун Сэтгэлгээнд
хөрөнгө оруулагч



Итгэлтэй
харилцагч



Эрхэм хэрэглэгч



Эрүүл чанартай
Бүтээгдэхүүн



Ёс зүйтэй
бизнес

МОНОС ХҮНС ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монос Хүнс ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр нийт хувьцаа эзэмшигчдэдээ хүртээмжтэй байх үүднээс танхимаар болон цахимаар зохион байгуулсан юм. Нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.1 хувийн ирцтэй хурлаар гүйцэтгэх захирал А.Отгондарь 2022 оны үйл ажиллагааны тайлан, гол үр дүнг танилцуулж өнгөрөгч онд 6 брэндийн 14 нэр төрлийн шинэ болон шинэчлэгдсэн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай байршуулж ажилласан талаар онцолсон. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн дарга Х.Ананд үйл ажиллагаа амжилттай, өсөлттэй ажилласныг дүгнэж нэгж хувьцаанд 2.4 төгрөгийн ногдол ашиг тараахаар болсныг мэдэгдсэн юм.

МОНОС ХҮНС ХК ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН ДАХИН НЭГ ЭМНЭЛГИЙН ХҮҮХДИЙН ӨРӨӨГ ТОХИЖУУЛЛАА



Монос Хүнс хувьцаат компани хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан өөрсдийн санаачилгаар ГССҮТ-ийн Түлэгдлийн эмнэлгийн Түлэнхийн нөхөн сэргээх хүүхдийн тасгийн өрөөг иж бүрэн засварлан, тохижуулсан. Тус өрөөнд 21 аймаг болоод нийслэлийн бүх дүүргийн түлэгдсэн хүүхдүүд хэвтэн эмчлүүлдэг. Жилд дунджаар 2000 гаруй хүүхэд түлэнхийн нөхөн сэргээх эмчилгээний өмнө болон дараа үеэр гэр бүл, асран хамгаалагчийн хамт цагийг өнгөрүүлдэг байна. Тохижилтын ажлын талаар “Хүүхдэд ээлтэйгээр тохижуулсанд бие нь эдгэрч, инээд хөөрөөр бялхаж ижий аавдаа очиж буй мянга мянган хүүхдийн өмнөөс талархал илэрхийлье” хэмээн эмнэлгийн төлөөллүүд сэтгэгдлээ хэлсэн юм.

**“ХЭНЭГТЭЙ МОНГОЛ ЭР ХҮН” НИЙГМИЙН
НӨЛӨӨЛЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЛЭЭ**

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд эрэгтэй хүний талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчилж, эрүүл оршихуйд нь бодит шийдэл санал болгох замаар сэтгэл зүй болон биеийн эрүүл мэндийн хувьд бие даасан, ухамсарт эрх хүнийг бүтээлцэх, улмаар монгол эрэгтэй хүний дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд туслах зорилго бүхий төслийг 2023 оны эхний хагаст амжилттай хэрэгжүүлж эхэллээ. Нийгмийн хэвшмэл ойлголтыг “ҮЛ СОНСОХ” шинэ хэв маягийг бүтээгч, өөртөө анхаардаг, хэрсүү ухаантай ХЭНЭГТЭЙ МОНГОЛ ЭР ХҮН байхыг нийт эрчүүддээ болон нийгэмд уриалсан олон төрлийн идэвхжүүлэлт хийсэн нь давхардсан тоогоор 11 сая хүнд хүрсэн байна.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТОГТМОЛ ХЭРЭГЖҮҮЛЖ
БАЙНА**

Монос Хүнс ХК нь 2023 оны эхний хагаст иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд бүтээгдэхүүний танилцуулга, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгөх зорилготой “Эрүүл мэндийн өдөрлөг, арга хэмжээ”-г Төв аймгийн Эрдэнэ сумд үйл ажиллагаа явуулдаг Аржанчивлан болон Өвөржанчивлангийн рашаан сувилалд зохион байгууллаа. Эрүүл мэндийн боловсрол олгох замаар бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл хүргэдэг тус арга хэмжээнд сувилуулагч 250 гаруй иргэн мөн сувиллын ажилтан, албан хаагчдыг хамруулж өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар эмч мэргэжилтнүүдийн зөвлөгөөг хүргэсэн юм.

“ҮРСЭЭ УСТАЙ ҮЛДЭЭЕ” УРИАГ ОЛОН НИЙТЭД ТҮГЭЭЛЭЭ



Экос брэндийн зүгээс жил бүр “ҮРСЭЭ УСТАЙ ҮЛДЭЭЕ” ус хэмнэх уриалгыг гарган тодорхой ажлуудыг хэрэгжүүлдэг. Энэ жил орон сууцны айлууд усаа хэрхэн хэмнэж болох туршилтыг санаачлан “Моод” нэвтрүүлэгтэй хамтран хэрэгжүүллээ. Ингэснээр 10 хоногийн хугацаанд туршилтад оролцсон айлуудын 70-80 хувь нь дунджаар 30 хүртэлх хувиар усаа хэмнэж чадсан үр дүн гарсан юм.

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН СУУРЬ ҮНЭЛГЭЭГ ХИЙЛГЭВ



Монос Хүнс ХК нь эрүүл мэндийг дэмжсэн хүнс болон хүнсний нэмэлт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын (БОНЗ) суурь үнэлгээг 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хооронд “Ризилиенс консалтинг сервис” ХХК-аар хийж гүйцэтгүүллээ. БОНЗ-ын суурь үнэлгээг нийт 225 шалгуур үзүүлэлтээр хийж үзэхэд 153 шалгуур биелсэн буюу нийт 10 оноо авахаас 6.9 оноог авсан байна.

МИЛИНО БРЭНД ОУ-ЫН “PRODEXPO-2023” ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦЛОО



Монос Хүнс ХК-ийн чацаргана, аньс, тарагтай ааруултай үрлийг “Милино” брэнд нэрийн дор ОХУ-д зохион байгуулагдсан.

“PRODEXPO-2023” үзэсгэлэнд танилцуулаа. Тус үзэсгэлэнд нийтдээ 50 гаруй орны 2070 компани өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулсан бөгөөд цар тахлын өмнөх үеэс өндөр үзүүлэлттэй жил болж буйг зохион байгуулагчдын зүгээс онцолж байлаа.

“МИЛИНО” БРЭНДИЙН ААРУУЛТАЙ ҮРЛИЙГ ЕВРОАЗИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРГАЛАА




Монос Хүнс ХК 2022 онд Орос, Хятад, Америк, Солонгос, Киргиз улсын зах зээлд нэвтрэхээр төвлөрч ажилласны үр дүн гарч эхэллээ.


Тухайлбал, Австри улсад төвтэй “TSC” компанийн ОХУ дахь салбар “TSC Food Products RU” ХХК-ийн захиалгаар “МИЛИНО” брэндийн “Тарагтай ааруултай үрэл” бүтээгдэхүүнийг хөгжүүлж, эхний нийлүүлэлтээ амжилттай хийсэн.

Мөн тус компанийн 2 дахь захиалга болох “МИЛИНО” брэндийн “Чацарганатай ааруултай үрэл” бүтээгдэхүүнийг хөгжүүлж, нийлүүлэлт хийхээр төлөвлөн бэлтгэл ажилдаа орлоо. Ингэснээр “МИЛИНО” брэндийн ааруултай үрэл бүтээгдэхүүнийг ОХУ-аас гадна Евроазийн эдийн засгийн холбооны таван улсад борлуулах боломжтой боллоо.

МХБ ДЭЭРХ КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ




Монос Хүнс ХК ногдол ашиг тараахаар боллоо




Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хурлаар 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгийн 30% болох 981 сая төгрөг буюу нэгж хувьцаанд 2.4 төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоож, ногдол ашгийг Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ТӨХХК-аар дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс хуваарилахаар шийдвэрлэсэн.

2021.12.31-ны хаалтын ханш: 113.2₮	2023.6.30-ны хаалтын ханш: 104.1₮	Хамгийн дээд ханш: 2023 он 122.3₮	Арилжааны дүн: 2023 он 989.5 сая.₮
2022.12.31-ны хаалтын ханш: 124.7₮	Хамгийн доод ханш: 2023 он 100.4₮	Арилжааны тоо ширхэг: 2023 он 8.9 сая ширхэг	


БОРЛУУЛАЛТ



НИЙТ АШИГ



ЕБИТДА



ЦЭВЭР АШИГ



Санхүү байдлын тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2022.06.30	2023.06.30	Өөрчлөлт %
ХӨРӨНГӨ	26,458.7	45,017.0	70%
Эргэлтийн хөрөнгө	13,743.2	13,337.2	-3%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	106.5	586.0	450%
Дансны авлага	3,725.1	5,290.8	42%
Татвар, НДШ – ийн авлага	48.1	565.4	1076%
Бусад авлага	65.7	146.7	123%
Бараа материал	6,313.9	6,179.3	-2%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	3,483.9	568.9	-84%
Эргэлтийн бус хөрөнгө	12,715.5	31,679.8	149%
Үндсэн хөрөнгө	12,060.6	29,967.7	148%
Биет бус хөрөнгө	569.2	469.3	-18%
Хойшлогдсон татварын хөрөнгө	55.1	70.2	27%
Бусад эргэлтийн бус хөрөнгө	30.6	1,172.6	3732%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	26,458.7	45,017.0	70%
Өр төлбөр	10,844.7	26,616.5	145%
Богино хугацаат өр төлбөр	5,087.6	11,828.9	133%
Дансны өглөг	1,107.0	1,007.4	-9%
Цалингийн өглөг	56.1	179.0	219%
Татварын өр	792.7	1,534.6	94%
НДШ - ийн өглөг	60.7	140.2	131%
Богино хугацаат зээл	1,788.6	7,260.0	306%
Хүүний өглөг	33.2	227.2	584%
Ногдол ашгийн өглөг	817.7	981.2	20%
Урьдчилж орсон орлого	41.3	42.0	2%
Нөөц /өр төлбөр/	153.7	150.4	-2%
Бусад богино хугацаат өр төлбөр	236.4	306.9	30%
Урт хугацаат өр төлбөр	5,757.1	14,787.6	157%
Урт хугацаат зээл	5,757.1	14,787.6	157%
Бусад урт хугацаат өр төлбөр	0.0	0.0	
Эздийн өмч	15,614.1	18,400.4	18%
Өмч - Хувьцаат	2,318.2	2,318.2	0%
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7	0%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	451.9	410.9	-9%
Хуримтлагдсан ашиг	6,008.2	8,835.6	47%

Орлого үр дүнгийн тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2022 Н1	2023 Н1	Өөрчлөлт %
Борлуулалтын орлого (цэвэр)	13,881.7	16,498.3	19%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	7,876.4	8,702.6	10%
Нийт ашиг (алдагдал)	6,005.3	7,795.7	30%
Бусад орлого	22.7	24.4	8%
Борлуулалт, маркетингийн зардал	2,715.8	3,631.5	34%
Ерөнхий ба удирдлагын зардал	1,153.3	1,499.3	30%
Санхүүгийн зардал	359.7	175.4	-51%
Бусад зардал	41.7	131.4	215%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-58.1	-35.1	-40%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	1,699.3	2,347.4	38%
Орлогын албан татвар	188.6	255.4	35%
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,510.7	2,092.0	38%

Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2022 Н1	2023 Н1
Эргэлтийн харьцаа / Current Ratio	2.7	1.1
Хөшүүргийн харьцаа/ Debt-to-EBITDA	2.26	4.84
Бие даалтын коэффициент / Shareholder Equity ratio	59%	41%
Өрийн харьцаа / Debt ratio	41%	59%
Нийт ашгийн хувь / Gross profit margin	43.3%	47.3%
Цэвэр ашгийн хувь / Net income margin	10.9%	12.7%
Нийт хөрөнгийн өгөөж / Return on Assets - ROA	5.7%	4.6%
Өөрийн хөрөнгийн өгөөж / Return on Equity - ROE	9.7%	11.4%

Монос Хүнс ХК-ийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон засаглалын (БОНЗ) суурь үнэлгээг “Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК -аар хийж гүйцэтгүүлсэн. Үнэлгээ хийхдээ НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ), Олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын түгээмэл мөрддөг Байгаль орчин, Нийгэм, Засаглалын шаардлагууд болох Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК): Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, Европын холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандарт конвенц, тунхаглал болон Монгол Улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан шаардлагуудыг шалгуур болгон авч үзсэн.



БОНЗ нь тухайн байгууллагын дотоод ба гадаад орчинд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх багц шалгууруудаас бүрддэг.

Байгаль Орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын суурь үнэлгээг нийт 225 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд **153 ШАЛГУУР БҮРЭН БИЕЛСЭН**, 24 шалгуур бүрэн бус, 48 шалгуур биелээгүй байна. БОНЗ-ын үнэлгээний шалгууруудыг нэгдсэн оноогоор авч үзвэл нийт 10 оноо авах ёстойгоос 6.9 оноог авсан байна.




“...Үнэлгээний үр дүнгээс харахад “МОНОС ХҮНС” ХК нь нийгмийн хариуцлагаа ухамсарласан, үйл ажиллагаандаа БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН хувьд АРВИН ОЛОЛТ АМЖИЛТТАЙ, үйл ажиллагаа нь САЙН дадалтай байна...”

Ризилиенс Консалтинг Сервиз ХХК


МААМУУ ЖИМСТЭЙ ШАХМАЛ ААРУУЛЫГ ХУДАЛДААНД ГАРГАЛАА

Хүүхдийн чихрийн хэрэглээг багасгах зорилгоор уламжлалт цагаан идээг орчин үеийн технологитой хослуулан бүтээсэн Маамуу жимстэй шахмал ааруулыг худалдаанд гаргалаа. Аньс, нэрс, чацарганатай шахмал ааруул нь **С, D, В, А** амин дэм, уураг болон кальциар баялаг тул хүүхдийн өсөлт хөгжилт, яс, шүдний бэхжилтийг дэмжих сайн нөлөөтэй.




ААМУУ

Таамуу




90%



ҮЙЛДВЭРИЙН
БАРИЛГА

90%



ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖ

95%



БҮТЭЭГДЭХҮҮН
ХӨГЖҮҮЛЭЛТ

ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН



SGS Certified

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ЦЭНЭГЛЭГЧ

МОНОС
ХҮНС

2023©